

ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНЫ ХҮН АМ ЗҮЙН ЦОНХНЫ ҮЕИЙН ОНЦЛОГ БА МОНГОЛ УЛС

Д.Тунгалаг*

Тухайн улсын хүн амын дундаж наслалт нэмэгдэж, төрөлт буурч, хүн амын өсөлт удаашран хөдөлмөрийн насны хүн амын тоо хамгийн их болох тэр үеийг хүн ам зүйн цонх гэдэг. Дэлхийн улс орнуудад хүн ам зүйн цонхны үргэлжлэх хугацаа янз бүр, тухайлбал Япон улсад 40 жил үргэлжилж 2000 оны үед хаагдсан байхад Хятад, Өмнөд Солонгост 50 жил үргэлжлэх ба 2040 он гэхэд хүн ам зүйн цонх хаагдах төлөвтэй байх жишээтэй. Энэ үеийг зөв зохистой ашиглаж чадвал хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтийн хурдыг түргэсгэх боломжтой гэдгийг зарим орны туршлагаас харж болох юм.

Хүн амын шилжилтийн онолоор хүн ам зүйн цонх дөрвөн үе шаттай. Үүнд:

- Төрөлт, нас баралт хоёулаа өндөр хувьтай байх.
- Нас баралт буурч, төрөлт өндөр хувьтай байх. Энэ үед хүн ам өсдөг.
- Нас баралт, төрөлт хоёулаа буурч тогтворжих.
- Хүн амын дунд насжилт явагдсан байх тул нас баралт төрөлтөөс давах. Өөрөөр хэлбэл, 60-аас дээш настай хүмүүсийн тоо нэмэгдэнэ гэсэн үг.

Нэгэнт буурсан төрөлтийг өсгөхөд хэцүү. Ер нь өсгөсөн улс ч байдаггүй. Тиймээс нэг гэр бүл хоёроос илүү хүүхэд төрүүлснээр хүн амын өсөлтийг удаан барьж чадна. Мөн энэ үед хамгийн их ажлын байрыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хүн амынхаа эрүүл мэндэд анхаарах, эдийн засгийн өсөлтөө хурдасгах, орлого хэрэглээг нэмэгдүүлэх, хөрөнгийн хуримтлал бий болгох шаардлагатай байдаг.

Хөгшин Европт хүн амын цонх нь хаагдсан олон орон байдаг. Хүн ам зүйн цонхны үе хаагдсанаар гадаадаас ажиллах хүч авах зайлшгүй шаардлага тулгардаг. Хүн амын цонх хаагдсан үеэс хойш эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлэхэд хэцүү, ажиллах хүчний хомсдолд орох аюултай. Тухайлбал, Австралид нягтлан бодогч, Японд асрагчийн орон тоонд гаднаас ажиллах хүч авдаг жишээ байна.

Одоогоор Япон, Итали улсын хүн амын цонх хаагдаад байна. Харин Чили, Хятад улсынх 10 жилийн дотор, Энэтхэг улсынх 10 жилийн

* МУИС, ОУХС-ийн багш доктор (Ph.D), профессор

дараа хаагдах төлөвтэй. Харин Афганистан, Уганда улсын хүн амын цонх хараахан нээгдээгүй байна. Мөн Герман, Япон, Итали, Португаль, Бельги зэрэг 15 улс хүн амын насжилтаараа тэргүүлдэг. Франц улс хүн амын насжилтын үеийг 115 жилд туулсан бол Канад улс 65, Япон улс 26 жилийн дотор туулжээ. Асар богино хугацаанд төрөлтийн тоо буурсан нь насжилтын процессыг хурдасгахад нөлөөлсөн байна. Тухайлбал, 2050 онд Энэтхэг улс 1.5 тэрбум хүн амтай болж Хятад улсыг ардаа орхих судлаачдын тооцоо гарчээ.

Өндөр хөгжилтэй орнуудад хүн амын төрөлт багасч хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудад нэмэгдэж байгаа нь тухайн орны хөгжлийн түвшин, эдийн засгийн өсөлт, хүчин чадал, улмаар эрүүл мэндийн салбарын хөгжил зэрэг олон хүчин зүйлээр тайлбарлагддаг. Эдгээр үндсэн хүчин зүйлүүд нь улс бүрд өөр өөр байна. Тухайлбал;

Өмнөд Солонгос улс

Хүн ам зүйн цонхны үеийг Өмнөд Солонгос амжилттай ашиглаж Азийн бар улс болсон туршлагатай. Тухайлбал, Өмнөд Солонгос ажиллах хүчний шингээлт сайтай худалдааны салбар, жижиг дунд үйлдвэрийг экспортын чиглэлд хөгжүүлж нээлттэй худалдааг бий болгон амжилтад хүрсэн орон. Өмнөд Солонгосын нийт хүн амын дийлэнх нь хот суурин газар амьдардаг ба 1970-1990 оны хооронд эдийн засгийн өсөлттэй холбоотойгоор орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт эрчимтэй явагдсан. Өмнөд Солонгосын нийслэл Сөүл хот 10.3 сая оршин суугчтай хамгийн том хот. Бусад томоохон хотуудад Бусан (3.65), Инчеон (2.63), Тэгү (2.53), Тэжон (1.46), Гванжү (1.41), Улсан (1.10) багтдаг.

Хоёр Солонгос хуваагдсаны дараа дөрвөн сая орчим цагаачид Хойд Солонгосоос дүрвэн ирсэн байдаг. Солонгосын иргэд 1950-1953 оны Солонгосын дайны дараа АНУ, Канад руу нэлээдгүй цагаачилсан ба энэ байдал 1990 оны дунд үеэс буурч эхэлжээ. Өмнөд Солонгосын дундаж наслалт 77 ба үүнээс эмэгтэйчүүдийнх 80, эрэгтэйчүүдийнх 73 болж байна.

Солонгос дахь гадаадын иргэдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа ба 2007 оны байдлаар 1 сая гаруй гадаадын иргэн байгаагаас 100 гаруй мянга нь Солонгосын иргэдтэй гэрлэсэн байна. Одоо Өмнөд Солонгост 400 гаруй мянган гадаадын ажилчин ажиллаж, 220 гаруй мянган хууль бус цагаач байна гэсэн судалгаа гарчээ.

Орон нутагт амьдрах сонирхолтой эмэгтэйчүүдийн тоо буурсан тул Солонгосын фермерүүд (тариаланчид) Зүүн өмнөд Ази, Зүүн Европын ядуу орноос эхнэр авах үзэгдэл ихэссэн. 2006 оны судалгаагаар шинээр гэрлэсэн фермерүүдийн 41 хувь нь гадаад орны бүсгүйчүүдтэй суусан байна.

Япон улс

Японы хүн ам нь хөгширч байгааг 2004 онд нийт хүн амын 19.5 хувь нь 65-аас дээш насныхан байсан бол 2010 он гэхэд 23,1 хувь болж өссөнөөс харж болно. Японы Саппоро, Сэндай, Токио, Сайтама, Чиба, Кавасаки, Ёкохама, Нагояа, Киото, Осака, Кобэ, Хирошима, Китакюүшюү, Фүкүока зэрэг саяас дээш хүн ам бүхий хотод хүн амын төвлөрөл ихээр явагдаж байна. Газар нутгийн 10 хувьд нь хүн амын 90 хувь нь амьдардаг гэсэн судлаачдын тоо баримт ч бий. Үүний нөгөө талд хөдөө орон нутагт хүн амын сийрэгшил, хөгшрөлт газар авч байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаанаас үзвэл япончуудын дундаж наслалт 2001 онд эрэгтэйчүүд 78.4, эмэгтэйчүүд 85.3 хувь байсан бол 2010 онд эрэгтэйчүүд 79.6, эмэгтэйчүүд 86,4 хувь болтлоо өссөнөөс харахад дэлхийд хамгийн урт насалдаг үндэстэн гэдэг нь тодорхой байна.

Хятад улс

БНХАУ газар нутгийнхаа хэмжээгээр дэлхийд гуравдугаарт ордог. Хүн ам нь 1.3 тэрбум, дэлхийн хүн амын 20 орчим хувийг эзэлдэг. 1979 оноос хүн амын өсөлтийг хязгаарлах бодлого явуулснаар Хятадын хүн ам жилд 8 сая орчмоор нэмэгдэж 2033 он гэхэд өсөлтийн оргилдоо хүрч 1 тэрбум 500 саяд хүрнэ гэж Хятадын Хүн ам болон төлөвлөгөөт төрөлтийн үндэсний хорооны дарга хатагтай Ли Бинг хэлсэн байна. Бээжин хотноо болсон “Өөрчлөлт, шинэчлэлийн бодлогын хэрэгжилт болон хүн амын хөгжил” чуулга уулзалт дээр тэрбээр хэлэхдээ “Төрөлтийн хэмжээг бага бөгөөд тогтвортой байлгаж хүн амын тоог тогтоон барих асуудал нь Хятадын өнөөгийн хүн ам болон төлөвлөгөөт төрөлтийн тэргүүн зэргийн чухал ажил хэвээр байх болно”¹ гэжээ.

НҮБ-ын мэдээлснээр Хятадын 15-аас доош насны хүүхдийн тоо 1976 онд түүхэн дээд хэмжээ буюу 360 орчим сая байжээ. Харин 2010 оны хүн амын тооллогоор тус улсын 0-14 насны хүүхдийн тоо 222 сая болжээ. 2010 оны байдлаар Хятадын хүн амын 16.6 хувь нь 14 хүртэлх насныхан болж байгаа нь арван жилийн өмнөхтэй харьцуулахад 6.29 хувиар буурсан үзүүлэлт болж байна. Өнгөрсөн 35 жилийн хугацаанд Хятадын бага насны хүүхдийн тоо 138 саяар буурсан бол ирэх 35 жилд энэ тоо улам багасч 80 сая болно гэж НҮБ-аас мэдээлжээ.

Хүн амын өсөлтийн хурд удааширч, хөгшин хүмүүсийн эзлэх хувийн жин нэмэгдэн, 2010 оны байдлаар 60-аас дээш насныхан хүн амын 13.3 хувийг эзлэх болсон нь 2005 онтой харьцуулахад 5.7 хувиар өссөн байна. Хятадын түүхэнд анх удаа хүн амынх нь тоо хотод хөдөөнөөсөө илүү

1. Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Хүн ам зүйн цонхны үеийн хөгжлийн бодлогын зарим асуудлууд” сэдэвт Үндэсний зөвлөлдөх уулзалтад оролцогчдод хандан ирүүлсэн илгээлтээс, УБ, 2010

болсон байна. Тус улсын статистикийн удирдах газрын мэдээлснээр Хятадын хотуудын хүн амын тоо 2011 онд 21 саяар нэмэгджээ. Одоо Хятадын хотуудын хүн амын тоо 690 сая орчим буюу нийт хүн амын 51,27 хувьтай тэнцэж байна. Харин хөдөөгийн хүн амын тоо 15 саяар буурчээ. Эдгээр тоо баримт нь шинжээчдийн гайхлыг төрүүлж байгаа, учир нь Хятад улсыг газар тариалангийн орон гэж зүй ёсоор үздэг байсан юм.

БНХАУ байгуулагдсанаас хойш хүн ам нь хурдацтайгаар өссөний улмаас Засгийн газраас 1979 онд “нэг хүүхэд”-ийн бодлого хэрэгжүүлж, төрөлтийг хязгаарлах болсон нь тус улсын эдийн засагт нааштай нөлөө үзүүлж байгаа билээ. Гэсэн хэдий ч төрөлтийг хязгаарлан хүн амын өсөлтийг бууруулж чадсан боловч иргэншилгүй хүүхдүүд болон хүүхдийн наймаа газар авах зэрэг сөрөг үр дагавар гарсаар байна. Хүүхдүүд дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтөд хувь нэмэр болохгүй, харин ч зарлага хэмээн үздэг байна. Тиймээс Хятадын одоогийн хүн амын наслалтын бүтэц хамгийн тохиромжтой үедээ байгаа ч хамгийн бүтээмж өндөртэй ажилладаг насныхан хөгширсөөр байна.

Харин хүн амын амьжиргааны түвшингээс доогуур буюу ядуурлын түвшинд буй хүн амын тоо 2009-2010 онд 9.9 саяар буурсан байна. Хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амын тоонд эзлэх хувь ихэнх байх нь татварын орлогыг нэмэгдүүлэн өсвөр болон өндөр настай иргэддээ үр өгөөжийг нь хүртээх бодлого хэрэгжүүлэхэд чухлаар нөлөөлдөг. Харин одоо Хятад улс эргэлтийн цаг дээрээ иржээ. Хөдөлмөрийн насныхны эзлэх хувийн жин буурч байгаа нь хүн амын бодлогоо өөрчлөх цаг болсныг харуулж байна.

Монгол улс

Үндэсний статистикийн газрын мэдээлснээр Монгол улсын хүн амын тоо 2012 оны эцсийн байдлаар 2 сая 869.5 мянга болсон байна. Энэ бол өнгөрсөн оны мөн үетэй, өөрөөр хэлбэл 2011 оны жилийн эцэстэй харьцуулбал ойролцоогоор 60 орчим мянган хүнээр нэмэгдсэн гэсэн үг. Хүн амын өсөлтийг нэгтгэн харуулдаг нэг гол чухал үзүүлэлт бол хүн амын ердийн өсөлт. 2010 оноос хойш гурван жилийн хугацаанд үндсэндээ манай улсын хэмжээнд төрөлтийн тоо хэмжээ нэмэгдэж нас баралт буурсан байна. Энэ хоёр үзүүлэлтийн зөрүүгээр тооцогддог хүн амын ердийн өсөлтийн хувьд 21 гэсэн тоо гарч байгаа нь хүн амын өсөлтийг харуулж байгаа нэг том үзүүлэлт юм.

Манай улсын хүн амын тооны өсөлтөд нөлөөлсөн нэг том чухал хүчин зүйл бол амаржсан эх амьд төрсөн хүүхдийн тоо юм. 2012 онд нийт 70-аад мянган эх амаржиж, нийт амьд төрөлтийн тоо 75 мянга байна. Амаржсан эхийн болон амьд төрөлтийн тоо тус бүрдээ 6 орчим хувиар нэмэгдсэн

байна. Монгол улсын хүн ам Их монгол улсын үед нэг сая орчим, Юань улсын үед хоёр сая гаруй байжээ. Харин Богд хаант Монгол улсын засгийн газрын хүн ам, мал хөрөнгийн 1918 оны албан ёсны тооллогоор 542,5 байсан байна. Ингээд 1925 онд 647.5, 1963 онд 101.1, 1989 онд 2044 мянга болж тогтмол нэмэгдсэн юм. Энэ хугацаанд мянган хүнд ноогдох хүн амын цэвэр өсөлт харилцан адилгүй байсан бөгөөд 1950-иад оны дунд үеэс 1980-аад оны эцэс хүртэл хүн амын өсөлтөөр тэргүүлэх улсын тоонд багтаж байжээ.

Монгол улс хүүхэд, залуусын орон гэх тодотголтойгоор олон жилийг үдсэн. Тэгвэл тухайн үеийн хүүхдүүд өнөөдөр нас бие гүйцэж залуусын эгнээг өргөтгөсөн бол залуус нь хижээл насны босго алхжээ. Харин хойноос залгамжлан шинээр мэндэлж буй хүүхдийн тоо алтан гахай жилийг эс тооцвол жар, далаад оны хаана нь ч хүрэхгүй хэвээр байна. Жар, дал, наяд оны хүүхдүүд ид хөдөлмөрлөх, бүтээх насандаа иржээ. Өөрөөр хэлбэл, ойрын жилүүдэд манай улсын нийт хүн амын дунд ажил хөдөлмөр эрхлэх боломжтой 15-60 насныхан зонхилох нь.

Өдгөө манай улсын ахмад настнууд нийт хүн амын зургаан хувийг эзэлж байна. Энэ тоо 10 хувь давахад нээлттэй цонх хаагдахад хүрнэ. Цонхыг хаахгүйгээр барих боломж гэж бараг байхгүй. Тиймээс цонх хаагдахаас өмнө амжиж хөдөлмөрийн насны хүн амаа ажлын байраар хангах, нэмүү өртгийг эх орондоо шингээх, мэргэжилтэй боловсон хүчнийг хүрэлцэхүйц хэмжээнд бэлтгэхээс эхлээд хийж хэрэгжүүлэх ажил цөөнгүй байна.

Хөгшин Европт хүн амын цонх нь хаагдсан олон орон бий. Гадаадаас ажиллах хүч авах болсон шалтгаан ч энэ. Тэгвэл бидэнд тийм үе тохиох уу гэдэг асуулт урган гарах нь мэдээж. Манай улсад эмэгтэйчүүд 55, эрэгтэйчүүд 60 насандаа тэтгэвэрт гардаг. Тэтгэвэрт гарах насыг тухайн улсын насжилтын байдал, цаашдын хандлагатай хамааруулан тогтоодог бөгөөд 2012 оны байдлаар монгол эмэгтэй хүний дундаж нас 74, эрэгтэй хүний дундаж нас 65 гэж гарчээ. Үүнээс үндэслэн эмэгтэй хүний тэтгэвэрт гарах насыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх судалгаа хийж эхлээд байна. Манай улсын хувьд хүн ам зүйн цонхны үед ирээд байгаа бөгөөд тэр бүр тохиохгүй энэ боломжийг үр ашигтай ашиглах асуудал бидний өмнө тулгараад байгаа билээ.

Энэ ч үүднээс 2010 оны 6-р сарын 9-ний өдөр 150 гаруй төлөөлөгч оролцсон “Хүн ам зүйн цонхны үеийн хөгжлийн бодлогын зарим асуудлууд” сэдэвт Үндэсний зөвлөлдөх уулзалт зохион байгуулж хүн амын цонхны үеийн онцлог, ашиглах боломж, Ази Номхон далайн орнуудын хүн амын насны бүтцэд гарч буй өөрчлөлт, түүний үр нөлөө, хүн ам зүйн цонхны боломжийг ашигласан туршлага, уул уурхайн салбарын хөгжлийн үе дэх хүн амын өсөлт, шинж байдал, түүний үр нөлөө зэрэг асуудлыг

хөндөж ярилцсан. Уг уулзалтад НҮБ-ын Хүн амын сангийн төлөөлөгч хатагтай Аржентина Матавел оролцсон юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж зөвлөлдөх уулзалтанд оролцогчдод хандан ирүүлсэн илгээлтдээ “Энэхүү Үндэсний зөвлөлдөх уулзалтын зорилго нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинэ ажлын байрыг бий болгох Засгийн газрын зорилтын хүрээнд Хүн ам зүйн цонхны үеийн боломжийг үр дүнтэй ашиглах, энэ асуудлыг хөгжлийн бодлогод тусган хэрэгжүүлэх асуудалд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын анхаарлыг хандуулах, бодлогын зөвлөмж гаргахад оршиж байна”² гэж тодорхойлсон.

Манай улсын хувьд хөдөлмөрийн насны хүн амын тоо хамгийн их байх үе буюу “хүн ам зүйн цонх”-ны үе тохиож байгаа энэхүү хүн амын цонхны үе ойролцоогоор 20-иод жилийн дараа дуусах төлөвтэй байна. Ингэснээр нийгмийн халамжид зарцуулдаг санхүүжилт, тухайлбал тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ нэмэгдэж 15-60 настай хүмүүс хөгширч хөдөлмөрийн насны хүн амын тоо буурна гэсэн үг. Энэ үеийг зохистой ашиглаж чадвал хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтийн хурдыг түргэсгэсч нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн нэмэгдэн иргэн бүр хадгаламж, хуримтлалтай болох нөхцөл бүрдэх юм.

Хүн ам зүйн цонхны үеийн энэхүү боломж хаагдсанаар насны хэв маягийн дараагийн үе болох хүн ам насжих үйл явц эхэлдэг. Хүн амын насжилтын үед ахмад настанд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зардал нэмэгдэж, төсөвт багагүй ачаалал нэмэгддэг байна.

Монгол улсад 1970-аад оны дунд үеэс буурч эхэлсэн төрөлтийн түвшин 1990-ээд оноос эрчимжсэн бөгөөд 2000-аад оны дунд үеэс харьцангуй тогтворжиж ирсэн. 1979 онд манай улсын хүн амын 44.3 хувь нь 0-14 насны хүүхэд, 48.5 хувь нь 15-59 насны хөдөлмөрийн насны хүн ам байсан бол 2011 оны байдлаар 26,6 хувь нь 0-14 насны хүүхэд, 67.7 хувь нь 15-59 насны хүн ам болж өөрчлөгдсөн. Энэ нь насны бүтцийн хувьд ихээхэн өөрчлөгдөж хүн ам зүйн цонхны таатай үе эхэлснийг гэрчилж байгаа юм.

Хүн амын хэтийн тооцооноос харахад хөдөлмөрийн насныхны нийт хүн амд эзлэх хувь 2025 оныг хүртэл 66.4 хувиас буурахгүй төлөвтэй байгаа нь хүн ам зүйн цонхны үе манай оронд 2025-2030 он хүртэл үргэлжлэхээр байгааг харуулж байна.

Улс орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, хүн амын орлого, амьжиргааг дээшлүүлэх, хүн амын өсөлтийг дэмжих боломж бүхий энэ таатай үеийг оновчтой ашиглах нь манай орны хувьд дахин давтагдашгүй хором юм. Хэрэв энэ үеийг зохистой ашиглаж чадахгүй бол ирээдүйд

2. Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Хүн ам зүйн цонхны үеийн хөгжлийн бодлогын зарим асуудлууд” сэдэвт Үндэсний зөвлөлдөх уулзалтад оролцогчдод хандан ирүүлсэн илгээлтээс, УБ, 2010

олон сөрөг үр дагавар, дарамт, тухайлбал ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх, үүнийг дагаж гэмт хэрэг, хүчирхийлэл, архидалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд бий болох аюултай. Иймд хүн ам зүйн цонхны үед хүн ам, гэр бүлийн бодлогыг оновчтой тодорхойлох, энэ үеийн боломжийг хамгийн үр ашигтайгаар ашиглаж эдийн засгийн өсөлтийг хурдасгах, ялангуяа уул уурхайн эдийн засагт түшиглэсэн энэ цаг үед хүний нөөцийг оновчтой байршуулах шаардлага тулгарч байна.

Манай улс одоогоор дээр дурьдсан дөрвөн үе шатны нас баралт, төрөлт хоёулаа буурч тогтворжих гурав дахь үед ирээд байна. Үүнийг ямар ч улс тойрч чадахгүй. Манай улс “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-доо хүн амын өсөлтийн хурдыг 2.4 хувиас бууруулахгүй гэж заасан. Энэ нь боломжгүй зүйл. Манай улсын хүн амын жилийн өсөлтийн хурд 2011 оны байдлаар 1.1 хувьтай байна. Монголын хүн амын төрөлт нэмэгдэж байгаа боловч өсөлтийн хурд буурч байгаа. Тухайлбал, 1970-аад онд төрөлт жилд 70 гаруй мянга байсан бол 1990-ээд онд 40 гаруй мянга болж буурчээ. Өөрөөр хэлбэл социалист нийгмийн үед эмэгтэйчүүд олон хүүхэд төрүүлдэг байсан. Учир нь төр засгаас хүнээ өсгөх, олон хүүхэд төрүүлэх хүн амын бодлого явуулснаар хүн амын тооны өсөлтийн хурд харьцангуй өндөр байсан бол жил өнгөрөх тусам төрүүлэх хүүхдийн тоо буурч одоо үеийн залуучууд хоёроос дээш хүүхэд төрүүлэхгүй гэдэг болсон. Төрөлт буурах нь хүүхэд насны хүн амын тоо буурахад нөлөөлдөг.

Хүн амын өсөлтийн хурдыг 2.1 хувьд барьж байхын тулд гэр бүл тус бүр хоёроос илүү хүүхэд төрүүлэх хэрэгтэй. Хэрэв нас баралтын түвшин өндөр байвал гурваас олныг төрүүлэх шаардлагатай болно. Гэсэн ч манай улсын хүн амын өсөлтийн хурд 1.8 хувьд хүрээд тогтворжино гэж судлаачид таамаглаж байгаа.

60-аас дээш настай хүний тоо нийт хүн амын 10 хувиас хэтрэхийг хүн амын цонх хаагдах үе гэж үздэг. Одоо манай улсын 60-аас дээш настай хүн нийт хүн амын 6 орчим хувийг эзэлж байна. Энэ хугацаанд цонхыг хаахгүй удаан барьж чадсан улс хөгждөг жамтай. Үүнийг хүн амын хамгийн ашигтай үе буюу хөдөлмөрийн бүтээмж өндөр байх үе гэж үздэг. Энэ нь одоогийн төрөлтийн тоог бууруулахгүй аль болох удаан хугацаанд барих шаардлагатай гэсэн үг юм.

Монгол улсын 1969, 1979, 1989, 2000, 2010 оны хүн амын суваргаас харахад хүн амын бүтэц бүрэлдэхүүн нэлээд өөрчлөгдсөн. Хүн ам ерөнхийдөө залуу насны бүтэцтэй байснаа завсрын гэж хэлж болохоор бүтцэд шилжсэн байна. Энэхүү байдал нь хүн амын төрөлтийн түвшин ихээхэн буурч, хүн ам хөгшрөх хандлагатай болж байгаа буюу хүүхэд залуучуудын хувийн жин буурч, насанд хүрэгсэд буюу хөгшин хүмүүсийн хувийн жин өсч байгааг харуулж байна. 1990-ээд оноос эхлэн төрөлтийн

түвшин тогтвортойгоор буурсаар байна.

Ийнхүү хүн амын дунд эдийн засгийн идэвхтэй хүн ам нэмэгдэж байгаа хүн ам зүйн өөрчлөлт нь улс орныхоо болон гэр бүл, хувь хүний хөгжлийг хангах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах сайхан боломжийг бидэнд олгож байна. Ялангуяа энэ үе нь Монгол улсад уул уурхай, дэд бүтцийн салбар эрчимтэй хөгжиж байгаатай давхцаж байгаагаараа онцлогтой юм. Гэвч хүн ам зүйн цонхны энэ үед дээрх боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадах эсэх нь хамгаас чухал асуудал болоод байна.

Монгол улс хүүхэд, залуусын орон гэх тодотголтойгоор олон жилийг үдсэн. Тэгвэл тухайн үеийн хүүхдүүд өнөөдөр нас бие гүйцэж залуусын эгнээг өргөтгөсөн бол залуус нь хижээл насны босго алхжээ. Харин хойноос залгамжлан шинээр мэндэлж буй хүүхдийн тоо жар, дал, наяд оныхтой харьцуулахад буурсан үзүүлэлт байна. Тэд ид хөдөлмөрлөх, бүтээх насандаа иржээ. Өөрөөр хэлбэл, ойрын жилүүдэд манай улсын нийт хүн амын дунд ажил хөдөлмөр эрхлэх боломжтой 15-60 насныхан зонхилох хувийг эзлэх нь гэсэн үг. Цагтаа Монголын хамгийн өнөр гэр бүл 12-15 хүүхэдтэй байсан бол өдгөө 3-5 хүүхэдтэй гэр бүл хамгийн өндөрт тооцогдох болжээ.

Хөгшин Европт хүн амын цонх нь хаагдаж гадаадаас ажиллах хүч авах болсон олон орон бий гэдгийг дээр дурьдсан. Тэгвэл бидэнд тийм үе тохиох уу гэдэг асуулт урган гарах нь мэдээж. Манай улсад эмэгтэйчүүд 55, эрэгтэйчүүд 60 насандаа тэтгэвэрт гардаг. Тэтгэвэрт гарах насыг тухайн улсын насжилтын байдал, цаашдын хандлагатай хамааруулан тогтоодог бөгөөд 2012 оны оны байдлаар монгол эмэгтэй хүний дундаж нас 74, эрэгтэй хүний дундаж нас 65 гэж гарчээ. Үүнээс үндэслэн эмэгтэй хүний тэтгэвэрт гарах насыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх судалгаа хийгдэж эхлээд байна.

Хэдийгээр хөдөлмөрийн чадвартай хүмүүс нийт хүн амын тоонд зонхилж, ахмад настны тоо буурч байгаа ч ажилгүйдэл, ядуурал тууштай буурахгүй байгаа нь анхаарал татах асуудал болоод байна.

Монгол улсын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого нь эхний ээлжинд ажил эрхлээгүй байгаа монгол хүмүүсээ ажлын байраар хангах, тэдэнд ажил хөдөлмөр эрхлэх мэргэжил ур чадвар эзэмшүүлэх, хавтгайрсан халамжийн бодлогыг цэгцэлж, ажил хийх боломжгүй хүн бүр хөдөлмөр эрхлэн орлого олж, ар гэр, амьдрал ахуйгаа авч явах чадвартай болгоход чиглэгдэх ёстой.

Эдийн засгийн өсөлт тогтворгүй, тэнцвэртэй бус байгаа нөхцөлд “хүн ам зүйн цонх”-ны үе эхэлж, харьцангуй богино хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгаа учраас энэ асуудалд нухацтай хандаж, алсын хараатай бодлого, үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх шаардлага бидний өмнө

тулгарч байна. Түүнчлэн цаашдаа тэрхүү цонхыг дахин дахин нээж байхын тулд төрөөс залуу гэр бүлийг дэмжсэн бодлого тууштай явуулах шаардлага тулгарч байна. Учир нь хүүхдээ өсгөж торниулахын тулд багаар бодоход 2.5-3 жил зарцуулж байгаа гэсэн судалгаан дээр тулгуурлан хүүхдийн ясли, цэцэрлэг дутмаг байгаа асуудлыг анхааралдаа авч тодорхой арга хэмжээ авах шаардлагатай байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар 2012 онд улсын хэмжээнд ажил идэвхтэй хайж байгаа 35.8 мянган хүн Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн нь 2011 оны мөн үетэй харьцуулбал 21 мянгаар буурсан, харин 61,5 мянган хүн шинээр бүртгүүлж, үүнээс 35.3 мянган хүн ажилтай болсон гэсэн мэдээлэл гарчээ.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан судалгаагаар Монголд 267 мянга гаруй хүн ажилгүй байгаа тооцоо гарсан. Гэтэл жил бүр 15 мянга гаруй хүнийг гаднаас авч ажиллуулдаг ажээ. Түүний дийлэнх нь хятад ажилчид. Хувийн хэвшлийг түшиглэж монголчуудаа ажлаар хангах, монгол хүний хөдөлмөрийн үнэлэмжийг сайжруулах замаар энэ байдлаас гарах боломжтой. Оюутолгой, Тавантолгойд голдуу эрчүүд ажиллаж байгаа тул эмэгтэйчүүд, хүүхдийн асуудлыг анхаарч тодорхой арга хэмжээ авах, мөн ажлын чадвартай, боловсролтой иргэдээ БНСУ-д олноор гаргаж оронд нь Хятадын зах хязгаар мужийн мэдлэг боловсролгүй, нутагтаа гологдол иргэдийг олноор авчирч ажиллуулж байгаа буруу тогтолцоо байгаа талаар дүгнэлт гарсан байна.

Уул уурхайн баялгаа ашиглан эдийн засгаа хөгжүүлэх, баялаг боловсруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой энэ үед ажиллах хүчийг нэмэгдүүлэн эдийн засагт үр өгөөжөө өгөх боломжийг бүрдүүлэх нь чухал. Үүнд гэр бүлийн харилцааг маш чухалд авч үзэх хэрэгтэй гэж судлаачид үзэж байна. Одоогийн байдлаар монгол залуучууд удаан хугацаагаар гадаадад ажиллаж эх орон, ар гэрийнхээ эдийн засагт тус дэм болж, сайн нөлөө үзүүлж байгаа хэдий ч гэр бүлийн харилцаанд олон сөрөг үр дагавар гарсаар байна.

Төрөөс үүнд анхаарлаа хандуулж, оновчтой бодлогоор зохицуулах нь улсынхаа хүн капиталыг ашиглахад ихээхэн чухал нөлөөтэй. Уул уурхай түшсэн үйлдвэр байгуулахдаа тэнд ажиллах ажилчид нь урт, богино хугацаагаар гэр бүлийнхнээсээ хол амьдарч ажиллах бус харин байнга гэр бүлтэйгээ хамт байж ажиллавал ажлын бүтээмж нь ч өндөр, гэр бүлийн харилцаанд ч таатай нөлөөтэй байх юм. Энэ нь эргээд хүн амын өсөлт, улсынхаа хэтийн төлөвт чухал нөлөөтэй. Иймд уул уурхайн баялгаа боловсруулах үйлдвэр байгуулахын зэрэгцээ тэнд ажиллагсдын нийгмийн асуудал, тухайлбал орон сууц, үйлчилгээ, амьдрах таатай

нөхцлийг бүрдүүлэхэд ч анхаарах нь чухал гэдэг нь Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос хийсэн судалгаанаас харагдаж байна.

Дүгнэлт

Хүн ам зүйн цонхны үеийг бүрэн үр өгөөжтэй ашиглаж амжилтанд хүрсэн орнуудын туршлагыг судалж өөрийн оронд хэрэгжүүлэх Эдийн засгийн өсөлт тогтворгүй, тэнцвэртэй бус байгаа манай орны өнөөгийн нөхцөлд хүн ам зүйн цонхны үе эхэлж, харьцангуй богино хугацаанд үргэлжлэх төлөвтэй байгаа учраас аль болох богино хугацаанд эдийн засгаа өсгөх, улмаар хүн амынхаа амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хөдөлмөрийн насны хүн амаа ажлын байраар хангах, залуу гэр бүлийг дэмжих талаар төрөөс зөв оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хүн ам зүйн цонхны үе байнга давтагдахгүй!

Ашигласан номзүй

1. Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Хүн ам зүйн цонхны үеийн хөгжлийн бодлогын зарим асуудлууд” сэдэвт Үндэсний зөвлөлдөх уулзалтад оролцогчдод хандан ирүүлсэн илгээлт, УБ, 2010
2. “Хүн ам зүйн цонхны үеийн хөгжлийн бодлогын зарим асуудлууд” сэдэвт Үндэсний зөвлөлдөх уулзалтын илтгэлийн эмхтгэл, УБ, 2010
3. ‘East Asian Political Economy and Culture: Convergence and Divergence’, The 70th international conference of CIS, INHA university, Korea, 2012
4. Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос хийсэн судалгаа, мэдээ, УБ, 2010